



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2026/099/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Архангай аймаг

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Аудитор С.Оргил

Утас: 99197346

Цахим хаяг: [Info@shinilenmagadlakhui-audit.mn](mailto:Info@shinilenmagadlakhui-audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 148  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАН  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ М.ОДГЭРЭЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэхээр 151,030.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 939,532.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,028,490.1 мянган төгрөгийг зарцуулж 60,072.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Хайрхан сумын хүүхдийн цэцэрлэг нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн

зорилтын 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 95 хувиар тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	180,312,755.73	84,579,606.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	151,030,055.73	62,072,556.46
312	Банканд байгаа бэлэн мөнгө	151,030,055.73	62,072,556.46
3121	Төгрөг	151,030,055.73	62,072,556.46
31211	Төрийн сангийн харилцах	151,030,055.73	62,072,556.46
33	АВЛАГА	-	47,250.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	47,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,282,700.00	22,459,800.00
351	Түүхий эд материал	120,000.00	120,000.00
35130	Эм боох материал	120,000.00	120,000.00
354	Хангамжийн материал	29,162,700.00	22,339,800.00
35410	Бичиг хэргийн материал	2,509,500.00	3,131,500.00
35420	Аж ахуйн материал	26,125,200.00	13,238,200.00
35450	Барилгын засварын материал	528,000.00	528,000.00
35460	Хүнсний материал	-	5,442,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,191,107,134.20	1,040,760,046.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,191,107,134.20	1,040,760,046.66
392	Биет хөрөнгө	1,182,329,134.20	1,031,982,046.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,178,496,356.71	1,027,994,581.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,490,801.27)	(89,547,564.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,750,925.00	32,471,255.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,222,607.96)	(13,057,947.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,575,815.90	34,931,826.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,038,856.79)	(9,958,406.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,087,834.50	66,581,434.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,807,131.89)	(18,410,731.77)
39217	Ном	977,600.00	977,600.00
393	Биет бус хөрөнгө	8,778,000.00	8,778,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,778,000.00	8,778,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,371,419,889.93	1,125,339,653.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,050,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,050,000.00
413	Өглөг	-	1,050,000.00
4136	Бусад өглөг	-	1,050,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,050,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,371,419,889.93	1,124,289,653.12
51	Засгийн газрын хувь оролцоо	1,371,419,889.93	1,124,289,653.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	106,088,264.00	106,088,264.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,223,406,467.06	976,276,230.25
51210	Өмнөх үеийн үр дүн	1,223,406,467.06	1,223,406,467.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	(247,130,236.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	41,925,158.87	41,925,158.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,371,419,889.93	1,125,339,653.12

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,004,666,499.00	969,207,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,347,999.00	25,285,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,347,999.00	25,285,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	26,347,999.00	25,285,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	978,318,500.00	943,921,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	842,322,200.00	861,974,600.00

**Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,322,200.00	861,974,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,996,300.00	81,946,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,996,300.00	81,946,800.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	965,425,043.49	1,075,830,370.05
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	965,425,043.49	1,075,830,370.05
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	945,773,026.51	1,071,441,579.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,050,854.00	752,547,636.60
210101	Үндсэн цалин	427,224,802.00	479,175,141.00
210102	Нэмэгдэл	168,260,088.00	243,753,638.28
210104	Урамшуулал	25,565,964.00	29,618,857.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,018,734.93	88,390,102.67
210201	Тэтгэврийн даатгал	54,313,785.93	60,095,917.80
210202	Тэтгэмжийн даатгал	6,217,833.00	7,075,996.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,220,230.00	3,539,198.12
210204	Ажилгүйдлийн даатгал	3,034,445.00	3,539,198.12
210205	Эрүүл мэндийн даатгал	12,232,441.00	14,139,792.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,653,023.02	69,863,609.40
210301	Гэрэл, цахилгаан	4,139,083.02	8,004,852.00
210302	Түлш, халаалт	97,611,570.00	53,758,757.40
210303	Цэвэр, бохир ус	5,902,370.00	8,100,000.00
2105	Норматив зардал	64,139,400.00	69,402,000.00
210502	Хоол, хүнс	64,139,400.00	69,402,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,804,000.00	7,694,400.00
210604	Урсгал засвар	9,804,000.00	7,694,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,319,420.00	2,452,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,319,420.00	2,452,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,787,594.56	81,091,530.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,486,201.00	35,511,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,259,600.00	4,921,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,041,793.56	40,658,320.78
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19,652,016.98	4,388,790.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,652,016.98	4,388,790.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,652,016.98	4,388,790.60
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>39,241,455.51</b>	<b>(106,623,170.05)</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		-
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	140,507,066.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	140,507,066.76
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	<b>(140,507,066.76)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>39,241,455.51</b>	<b>(247,130,236.81)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	978,318,500.00	943,921,400.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	978,318,500.00	943,921,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	842,322,200.00	861,974,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	842,322,200.00	861,974,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	135,996,300.00	81,946,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	135,996,300.00	81,946,800.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	927,056,908.93	1,027,346,399.27

**Архангай аймгийн Хайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

21	УРСГАЛ ЗАРДАЛ	927,056,908.93	1,027,346,399.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	907,404,891.95	1,022,957,608.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,308,854.00	752,547,636.60
210101	Үндсэн цалин	427,482,802.00	479,175,141.00
210102	Нэмэгдэл	168,260,088.00	243,753,638.28
210104	Урамшуулал	25,565,964.00	29,618,857.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,760,734.93	88,437,352.67
210201	Тэтгэврийн даатгал	54,055,785.93	60,143,167.80
210202	Тэтгэмжийн даатгал	6,217,833.00	7,075,996.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,220,230.00	3,539,198.12
210204	Ажилгүйдлийн даатгал	3,034,445.00	3,539,198.12
210205	Эрүүл мэндийн даатгал	12,232,441.00	14,139,792.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,054,283.02	69,863,609.40
210301	Гэрэл, цахилгаан	4,139,083.02	8,004,852.00
210302	Түлш, халаалт	97,611,570.00	53,758,757.40
210303	Цэвэр, бохир ус	7,303,630.00	8,100,000.00
2105	Норматив зардал	63,361,000.00	74,844,100.00
210502	Хоол, хүнс	63,361,000.00	74,844,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,290,000.00	7,694,400.00
210604	Урсгал засвар	7,290,000.00	7,694,400.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,319,420.00	2,452,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,319,420.00	2,452,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,310,600.00	27,118,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,098,450.00	20,404,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,212,150.00	6,713,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,652,016.98	4,388,790.60
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,652,016.98	4,388,790.60
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,652,016.98	4,388,790.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,261,591.07	(83,424,999.27)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,054,500.00	5,532,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,054,500.00	5,532,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,054,500.00	5,532,500.00
223001	Бусад хөрөнгө	-	5,532,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,054,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,054,500.00)	(5,532,500.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	45,207,091.07	(88,957,499.27)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		151,030,055.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	151,030,055.73	62,072,556.46

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	106,088,264.00	41,925,158.87	1,223,406,467.06	1,371,419,889.93

9	Тайлант үеийн үр дүн			-247,130,236.81	-247,130,236.81
10	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	106,088,264.00	41,925,158.87	976,276,230.25	1,124,289,653.12

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	952,939,100.00	939,532,609.40	13,406,490.60	98.59
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	870,992,300.00	861,974,600.00	9,017,700.00	98.96
131001	Улсын төсвөөс санхүүжих	870,992,300.00	861,974,600.00	9,017,700.00	98.96
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,946,800.00	77,558,009.40	4,388,790.60	94.64
132001	Орон нутгийн төсвөөс	81,946,800.00	77,558,009.40	4,388,790.60	94.64
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	134,221,700.00		134,221,700.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	133,490,500.00		133,490,500.00	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>1,087,160,800.00</b>	<b>939,532,609.40</b>	147,628,190.60	86.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,087,160,800.00	1,028,490,108.67	58,670,691.33	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,087,160,800.00	1,028,490,108.67	58,670,691.33	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	784,174,100.00	752,547,636.60	31,626,463.40	95.97
210101	Үндсэн цалин	497,190,500.00	479,175,141.00	18,015,359.00	96.38
210102	Нэмэгдэл	270,136,000.00	243,753,638.28	26,382,361.72	90.23
210104	Урамшуулал	16,847,600.00	29,618,857.32	-12,771,257.32	175.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,533,900.00	88,437,352.67	9,096,547.33	90.67
210201	Тэтгэврийн даатгал	66,166,900.00	60,143,167.80	6,023,732.20	90.9
210202	Тэтгэмжийн даатгал	7,841,700.00	7,075,996.21	765,703.79	90.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,920,900.00	3,539,198.12	381,701.88	90.26
210204	Ажилгүйдлийн даатгал	3,920,900.00	3,539,198.12	381,701.88	90.26
210205	Эрүүл мэндийн даатгал	15,683,500.00	14,139,792.42	1,543,707.58	90.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,246,800.00	69,863,609.40	4,383,190.60	94.1
210301	Гэрэл, цахилгаан	10,964,200.00	8,004,852.00	2,959,348.00	73.01
210302	Түлш, халаалт	55,182,600.00	53,758,757.40	1,423,842.60	97.42
210303	Цэвэр, бохир ус	8,100,000.00	8,100,000.00		100
2105	Нормативт зардал	86,878,700.00	74,844,100.00	12,034,600.00	86.15
210502	Хоол, хүнс	86,878,700.00	74,844,100.00	12,034,600.00	86.15
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,700,000.00	7,694,400.00	5,600.00	99.93
210604	Урсгал засвар	7,700,000.00	7,694,400.00	5,600.00	99.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,923,700.00	2,452,300.00	1,471,400.00	62.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,923,700.00	2,452,300.00	1,471,400.00	62.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,703,600.00	32,650,710.00	52,890.00	99.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,989,900.00	25,937,110.00	52,790.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,713,700.00	6,713,600.00	100	100

2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,087,160,800.00	1,028,490,108.67	58,670,691.33	94.6
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		151,030,055.73	151,030,055.73	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		62,072,556.46	-62,072,556.46	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй, залруулаагүй 5,804.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 5,804.5 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 12,529.4 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Албан шаардлага

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 5,804.5 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс аваагүй, бусад этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "ерөнхий гэрээний арга" гэж захиалагчийн тодорхой хугацаанд давтамжтай худалдан авдаг, эсхүл байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээний нэгж дээд үнэ болон бусад нөхцөлийг тогтоосон ерөнхий гэрээг нэг ба түүнээс дээш оролцогчтой байгуулж, цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахыг"; 9 дүгээр зүйлийн 9.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ", 38 дугаар зүйлийн 38.1-т "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна".

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгуулл агад шилжүүлс эн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Цахим худалдан авалттай холбоотой	1	5,804.5	1	5,804.5								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>5,804.5</b>	<b>1</b>	<b>5,804.5</b>								